



# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 18 (303)

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ:

- *Аж ахуйн нэгж, байгууллагын орлогын албан татварын хуульд нэмэлт оруулах тухай*
- *Гаалийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай*

Улсын Их Хурлын Тамгын газар  
Улаанбаатар хот  
2003 он



# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Улаанбаатар хот 2003 оны тавдугаар сарын 12 № 18 (33)

## Гарчиг

### Нэг. МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

- |      |  |                       |     |
|------|--|-----------------------|-----|
| 260. | Аж ахуйн нэгж, байгууллагын орлогын албан татварын хуульд нэмэлт оруулах тухай | (2003-4-24-ний хууль) | 434 |
| 261. | Гаалийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай                            | (2003-5-1-ний хууль)  | 434 |

### Хоёр. МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

- |      |   |           |     |
|------|---|-----------|-----|
| 262. | Мицүо Игарашийг "Найрамдал" медалиар шагнах тухай   | Дугаар 54 | 434 |
| 263. | Шүүгч, ерөнхий шүүгчийн албан тушаалд томилох тухай | Дугаар 56 | 434 |
| 264. | Шүүгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай             | Дугаар 57 | 435 |
| 265. | Шүүгчийг сэлгэн ажиллуулах тухай                    | Дугаар 58 | 435 |
| 266. | Шүүгчийн бүрэн эрхийг түдгэлзүүлэх тухай            | Дугаар 59 | 435 |
| 267. | Шүүгчийн албан тушаалаас огцруулах тухай            | Дугаар 60 | 435 |

### Гурав. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

- |      |   |            |     |
|------|---|------------|-----|
| 268. | Ажилд томилох тухай                         | Дугаар 91  | 436 |
| 269. | Тогтоолд өөрчлөлт оруулах тухай             | Дугаар 92  | 436 |
| 270. | Хөшөө барих газрын байршлыг өөрчлөх тухай   | Дугаар 93  | 437 |
| 271. | Зарим хүнийг ажлаас чөлөөлөх, томилох тухай | Дугаар 94  | 438 |
| 272. | Зардлын зарим хэсгийг нөхөн олгох тухай     | Дугаар 95  | 438 |
| 273. | Улсын нөөцөөс өвс, тэжээл гаргах тухай      | Дугаар 96  | 438 |
| 274. | Тогтоол хүчингүй болсонд тооцох тухай       | Дугаар 97  | 440 |
| 275. | Тогтоолд нэмэлт оруулах тухай               | Дугаар 98  | 440 |
| 276. | Дүрэмд нэмэлт оруулах тухай                 | Дугаар 99  | 440 |
| 277. | Нөөцөд эм, биобэлдмэл бэлтгэх тухай         | Дугаар 100 | 440 |

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

201 снй 1 дүгээр  
арын 2-нй өдөр

Улаанбаатар  
хот

АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН ОРЛОГЫН АЛБАН  
ТАТВАРЫН ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

"Дүгээр зүйл. Аж ахуйн нэгж, байгууллагын олгогчид татварын хуулийн 5 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг 1 дэх заалтын 2 дахь өгүүлбэрийн дараа "Хэсгийн үйл ажиллагаа эрхэлдэг хрисой эрдэлийн санд" бусад үйл ажиллагаа эхэлдэг хрисоны болзошгүй алдагдлыг нөхөх нөхцөлд хариуцаж, эзэлийн болон бусад үйл

ажиллагаа зэрэг эрхэлдэг хоршооны тухайд аль нэг санд нь төвлөрүүлсэн мөнгөн хөрөнгийг татвар ногдох орлогоос хасч тооцно." гэж нэмсүгэй.

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

201 снй 1 дүгээр  
арын 1-нй өдөр

Улаанбаатар  
хот

ГААЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ  
ОРУУЛАХ ТУХАЙ

"Дүгээр зүйл. Гаалийн тухай хуулийн 14 дүгээр зүйлд дурдсан агуулгатай 3 дахь хэсэг нэмсүгэй:

асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн шийдвэрлэнэ."

"1. Төсөл, арга хэмжээ хэрэгжүүлэх эрлгөрбөг, тээврийн хэрэгслийг энэ зүйлийн 1 дэх хэсэгтээс дагуу гаалийн нутаг дэвсгэрт тр оруулах хугацааг 6 сараас илүү хугацаагаар снхг аадлагатай бол уг асуудлыг гаалийн

2 дугаар зүйл. Гаалийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн дугаарыг "4" гэж өөрчилсүгэй.

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

203 снй 1 дүгээр  
арын 3-нй өдөр

Дугаар 54

Улаанбаатар  
хот

Мицуро Игарашийг "Найрамдал"  
медалиар шагнах тухай

Минол Улс, Япон Улсын эдийн засгийн ялтыг ажиллагааг хөгжүүлэх, манай улсад элбсоы двшилттэй технологийг нэвтрүүлэхэд оуулж байла хувь нэмрийг нь үнэлж Япон Улсын эрэн "Д" корпорацийн дэд ерөнхийлөгч Мицуро

Игарашийг "Найрамдал" медалиар шагнасугай.

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ Н.БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

203 снй 1 дүгээр  
арын 10-нй өдөр

Дугаар 56

Улаанбаатар  
хот

Шүүгч, ерөнхий шүүгчийн албан  
тушаалд томилох тухай

"Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хууль"ийн 2 дугаар зүйлийн 16, "шүүхийн тухай" Монгол Улсын хуулийн 32 дугаар зүйлийн 1, 4 дэх заалтуудыг баримтлан, Шүүхийн ерөнхий зөвлөлийн аналг үдэслэн ЗАРЛИГ болгох нь:

Батзоригийг Ховд аймаг дахь сум дундын нэгдүгээр шүүхийн шүүгчийн, Дүндэвийн Цаяаг Өмнөговь аймаг дахь сум дундын шүүхийн ерөнхий шүүгчийн албан тушаалд тус тус томилсугай.

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ Н.БАГАБАНДИ

Зукрын Гүлбаршаг Баян-Өлгий аймаг дахь ун дундын шүүхийн шүүгчийн, Батжаргалын



## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2003 оны 4 дүгээр сарын 30-ны өдөр

Дугаар 57

Улаанбаатар  
хт

Шүүгчийн албан тушаалаас  
чөлөөлөх тухай

"Шүүхийн тухай" Монгол Улсын хуулийн 58 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1 дэх заалтыг баримтлан, Шүүхийн ерөнхий зөвлөлийн саналыг үндэслэн ЗАРЛИГ болгох нь:

Мөнхтөрийг Дорнод аймаг дахь сум дундын шүүхийн албан тушаалаас чөлөөлсүрэй

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.БАГ/БНЦ

Өөрөө хүсэлт гаргасан Паламын

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2003 оны 4 дүгээр сарын 30-ны өдөр

Дугаар 58

Улаанбаатар  
хт

Шүүгчийг сэлгэн  
ажиллуулах тухай

"Шүүхийн тухай" Монгол Улсын хуулийн 42 дугаар зүйлийн 1.3 дахь хэсгийг тус тус баримтлан, Шүүхийн ерөнхий зөвлөлийн саналыг үндэслэн ЗАРЛИГ болгох нь:

сум дундын шүүхийн шүүгчийн албан тушаалаас Говь-Алтай аймаг дахь сум дундын шүүхийн шүүгчийн албан тушаалд сэлгэн ажиллуулаарай.

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.БАГ/БНЦ

Шаравын Баттогтохыг Өмнөговь аймаг дахь

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2003 оны 4 дүгээр сарын 30-ны өдөр

Дугаар 59

Улаанбаатар  
хт

Шүүгчийн бүрэн эрхийг  
түдгэлзүүлэх тухай

"Шүүхийн тухай" Монгол Улсын хуулийн 57 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5 дахь заалт, 78 дугаар зүйлийн 4 дэх заалтыг тус тус баримтлан, Шүүхийн ерөнхий зөвлөлийн саналыг үндэслэн ЗАРЛИГ болгох нь:

татах зөвшөөрөл олгож, Эрүүгийн байцаан илтгээ хуульд заасны дагуу эрх бүхий байгуулаас хож шийдвэр гарах хүртэл шүүгчийн бүрэн эрхийг нь түдгэлзүүлсүгэй.

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.БАГ/БНЦ

Булган аймаг дахь сум дундын шүүхийн шүүгч Сүрэнхорын Амарыг эрүүгийн хариуцлагад

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2003 оны 4 дүгээр сарын 30-ны өдөр

Дугаар 60

Улаанбаатар  
хт

Шүүгчийн албан тушаалаас  
оцруулах тухай

"Шүүхийн тухай" Монгол Улсын хуулийн 59 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1 дэх заалтыг баримтлан, Шүүхийн ерөнхий зөвлөлийн саналыг үндэслэн ЗАРЛИГ болгох нь:

Дамдингийн Ганхунягийг Увс аймаг дахь сум дундын шүүхийн шүүгчийн албан тушаалаас оцруулгаарай.

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.БАГ/БНЦ

Шүүгчийн ёс зүйн дүрмийг ноцтой зөрчсөн

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2003 оны 4 дүгээр сарын 13-ны өдөр

Дугаар 91

Улаанбаатар хот

**Ажилд томилох тухай**

Засгийн газрын тухай хуулийн 18.5-ыг томилсугай.

үндэслэл: Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД**
**Н.ЭНХБАЯР**

нь:

Гоибокавын Занданшатарыг Монгол Улсын Хүнс, хөдөө аж ахуйн дэд сайдын албан тушаалд

**МОНГОЛ УЛСЫН САЙД,  
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ  
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА** **Ө.ЭНХТҮВШИН**

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2003 оны 4 дүгээр сарын 15-ны өдөр

Дугаар 92

Улаанбаатар хот

**Тогтоолд өөрчлөлт оруулах тухай**

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ найруулсугай.

нь:

Засгийн газрын 1998 оны 1 дүгээр сарын 15-ны өдрийн 5 дугаар тогтоолоор баталсан "Хүн амын эрүүл мэндийн боловсрол үндэсний хөтөлбөр"-ийн "Найм" дахь бүлгийг хавсралт ёсоор өөрчлөн

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД**
**Н.ЭНХБАЯР**
**ЭРҮҮЛ МЭНДИЙН  
САЙД**
**П.НЯМДАВАА**
*Засгийн газрын 2003 оны 92 дугаар тогтоолын хавсралт*

### НАЙМ. ХӨТӨЛБӨРИЙН ҮР ДҮНГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	2005 онд хүрэх түвшин	Холбогдох хөтөлбөр
1. Эрүүл мэндийг дэмжигч сургуулийн тоо	26 (2001 он)	50	"Хүүхдийн хөгжил, хамгаалал" үндэсний хөтөлбөр
2. Эрүүл мэндийг дэмжигч байгууллагын тоо	25 (2001 он)	100	
3. 18 хүртэлх насны бүрэн шүдтэй хүүүүсийн эзлэх хувь	62.5 (1999 он)	72.5	"Амны хөндийн эрүүл мэнд" үндэсний хөтөлбөр
4. Урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан ахмад настны эзлэх хувь	27.4 (1999 он)	35	"Ахмад настны эрүүл мэнд, нийгмийн хамгаалал" үндэсний хөтөлбөр
5. Нийт төрөлтөд 15-19 насны охидын төрөлтийн эзлэх хувь	9 (2000 он)	7.8	"Нөхөн үржихүйн эрүүл мэнд" үндэсний хөтөлбөр
6. Орчин үеийн контрацепцийн аргын хэрэглээний түвшин	33.4% (2000 он)	43%	
7. Иоджуулсан давс хэрэглэдэг эрхийн эзлэх хувь	46.0 (2002 он)	85	"Иод дутлын эмгэгтэй тэмцэх" үндэсний хөтөлбөр
8. Тэмбүүгийн өвчлөл:	(2002 оны тандалт судалгаа)	2005 оны тандалт судалгаа	"Халдварт өвчинтэй тэмцэх" үндэсний хөтөлбөр
-Жирэмсэн эмэгтэйчүүдэд хийсэн тэмбүү илрүүлэх ийлдэс судлалын шинжилгээний эерэгийн хувь	2.5		
-Цусны доноруудад хийсэн тэмбүү илрүүлэх ийлдэс судлалын шинжилгээний эерэгийн хувь	1.3		

9. Гепатит А-ийн өвчлөлийн түвшин (10000 хүн амд)	34.2 (1996-2000 он)	29.0	
10. Цусан суулгын өвчлөлийн түвшин (10000 хүн амд)	7.5 (1996-2000 он)	7.0	
11. Сум, өрхийн эмнэлгээр үйлчлүүлэгчдийн дотор сэтгэцийн эргүүл мэндийн анхны тусламж авсан иргэдийн эзлэх хувь	0.13 (2000 он)	6	"Сэтгэцийн эрүүл мэнд" үндэсний хөтөлбөр
12. Хүн амын осол гэмтлээс шалтгаалсан өвчлөл (10000 хүн амд)	274.5 (2002 он)	231.5	"Осол гэмтлээс сэргийлэх" үндэсний хөтөлбөр
13. Нийт хүн амын дотор илүүдэл жинтэй хүний эзлэх хувь	31.8 (2001 он)	26	"Хүн амын бие бялдрыг чийрэгжүүлэх" үндэсний хөтөлбөр
14. Жилд нэг хүнд ногдох тарилгын тоо	13 (2001 оны тарилгын аюулгүй байдлыг үнэлэх судалгаа)	10	"Аюулгүй тарилга" Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын төсөл
15. Өмөнгөөр хэвтэн эмчлүүлэгчдийн дотор I, II үеийн хорт хавдартай өвчтөний эзлэх хувь	17.3 (1996 он)	70.0	"Хорт хавдартай тэмцэх" үндэсний хөтөлбөр
16. Цусны эргэлтийн тогтолцооны өвчний өвчлөлийн тохиолдол	388.6 (2001 он)	380.0	"Зүрх судасны өвчнөөс сэргийлэх" үндэсний хөтөлбөр

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2003 оны 4 дүгээр сарын 16-ны өдөр

Дугаар 93

Улаанбаатар хот

**Хөшөө барих газрын байршлыг өөрчлөх тухай**

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Монгол угсаатны 2000 жилийн дурсгалын хөшөө барих газрын байршлыг Өвөрхангай аймгийн Хархорин сумын нутаг дэвсгэр дэх Өлийн хөтлийн овоон дээр болгон өөрчилж, төслийн хэрэгжүүлэгчээр Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамыг баталсугай.

2. Хөшөө барих ажлыг төсвөөс нэмэлт зардал гаргахгүйгээр 2003-2004 онд дуусгах талаар арга хэмжээ авахыг Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд А.Цанжид, Өвөрхангай аймгийн Засаг дарга О.Батмөнх нарт даалгасугай.

3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Хөшөө барих тухай" Засгийн газрын 1999 оны 8 дугаар сарын 25-ны өдрийн 130 дугаар тогтоолын 1, 2 дугаар зүйлийг хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН**
**ЕРӨНХИЙ САЙД**
**Н.ЭНХБАЯР**
**БАЙГАЛЬ ОРЧНЫ САЙД БӨГӨӨД**
**БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ**
**УХААНЫ САЙДЫН ҮҮРЭГ**
**ГҮЙЦЭТГЭГЧ**
**У.БАРСБОЛД**

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2003 оны 4 дүгээр сарын 18-ны өдөр

Дугаар 94

Улаанбаатар хот

Засгийн газрын тухай хуулийн 18.7-д заасныг болон Төрийн албаны зөвлөлийн дүгнэлтийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1 Өөр ажилд шилжих болсонтой холбогдуулан Самдангийн Банзрагчийг Байгаль орчны яамны Төрийн нарийн бичгийн даргын, Цэдэнгийн Ендонг Үйлдвэр, худалдааны яамны Төрийн нарийн бичгийн даргын, гадаадад суралцах болсон тул Равдангийн Жадамбааг Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яамны Төрийн нарийн бичгийн даргын үүрэгт ажлаас тус тус чөлөөлсүгэй.

2 Янсанжавын Адъяаг Байгаль орчны яамны Төрийн нарийн бичгийн даргын, Дамдинсүрэнгийн Сүрэнхорыг Үйлдвэр, худалдааны яамны Төрийн нарийн бичгийн даргын, Очирын Байгалмааг

Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан тушаалд тус тус томилсугай.

<b>МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД</b>	<b>Н.ЭНХБАЯР</b>
<b>БАЙГАЛЬ ОРЧНЫ САЙД</b>	<b>У.БАРСБОЛД</b>
<b>ҮЙЛДВЭР, ХУДАЛДААНЫ САЙД</b>	<b>Ч.ГАНЗОРИГ</b>
<b>НИЙГМИЙН ХАМГААЛАЛ, ХӨДӨЛМӨРИЙН САЙД</b>	<b>Ш.БАТБАЯР</b>

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2003 оны 4 дүгээр сарын 23-ны өдөр

Дугаар 95

Улаанбаатар хот

Улсын байнгын онцгой комиссын саналыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

Засгийн газрын нөөц хөрөнгөөс 5625.0 (таван сая зургаан зуун хорин таван мянга) мянган төгрөг гаргаж, Засгийн газрын 1999 оны 55 дугаар тогтлоор баталсан "Ой, хээрийг түймрээс урьдчилан сэргийлэх, түймэртэй тэмцэх арга хэмжээг үр дүнд хүргэсэн аймаг, сумаас гаргасан зардлыг нөхөн олгох журам"-д заасан болзлыг хангасан Дорнод, Сүхбаатар аймагт Улсын байнгын

Зардлын зарим хэсгийг нөхөн олгох тухай онцгой комиссын саналын дагуу олгохыг Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаанд зөвшөөрсүгэй.

<b>МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД</b>	<b>Н.ЭНХБАЯР</b>
<b>САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН САЙД</b>	<b>Ч.УЛААН</b>
<b>БАТЛАН ХАМГААЛАХЫН САЙД</b>	<b>Ж.ГҮРРАГЧАА</b>

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2003 оны 4 дүгээр сарын 23-ны өдөр

Дугаар 96

Улаанбаатар хот

Улсын байнгын онцгой комиссын саналыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Хаваржилтын байдал хүндэрсэн Баян-Өлгий, Увс аймгийн малчдын хэрэгцээнд зориулан хөнөөлттэй үнээр, эргэн төлөгдөх нөхцөлөөр улсын нөөцөөс олгох өвс, тэжээлийн хуваарийг хавсралт ёсоор баталсугай.

2. Хаваржилтын байдал хүндэрсэн Баян-Өлгий, Увс аймагт улсын нөөцөөс олгох өвс, тэжээлийг тухайн аймаг дахь улсын нөөцийн цэг, салбараас сумдад хүргэх тээврийн зардалд зориулж 3662.4 (гурван сая зургаан зуун жаран хоёр

Улсын нөөцөөс өвс, тэжээл гаргах тухай мянга дөрвөн зуун мянга) мянган төгрөгийг Улсын байнгын онцгой комисст төвлөрч байгаа гадаад орон, олон улсын байгууллагын хандив, тусламжийн хөрөнгөөс зохицуулан гаргахыг Улсын байнгын онцгой комиссын дарга, Батлан хамгаалахын сайд Ж.Гүррагчаад зөвшөөрсүгэй.

<b>Монгол Улсын Ерөнхий сайд</b>	<b>Н.ЭНХБАЯР</b>
<b>Батлан хамгаалахын сайд</b>	<b>Ж.ГҮРРАГЧАА</b>
<b>Хүнс, хөдөө аж ахуйн сайд</b>	<b>Д.НАСАНЖАРГАЛ</b>

ЭЛСЭМИН СЭЛЭРИЙН ДЭВЭЭ ОНЫ ЭГ СУУЦИАР  
ПОСТООЛЫН ХАЭСРАЛТ

БАЯН-ӨЛГИЙ, УВС АЙМГИЙН МАЛЧДАД ХӨНГӨЛӨЛТТЭЙ ҮНЭЭР,  
ЗРГЭН ТӨЛӨГДӨХ НӨХЦӨЛӨӨР УЛСЫН НӨӨЦӨС ОЛГОХ ӨВС,  
ТЭЖЭЭЛИЙН ХУВААРЬ

№	Хүлээн авах аймаг, сум	Өвсний хэмжээ			Тэжээлийн хэмжээ			Бүгд үнэ /мян. төг/	Тээврийн зардал	
		Боодол	Нэг боодол өвсний үнэ (төг)	Нийт үнэ (мян. төг)	Тн	Нэгж үнэ (мян. төг)	Нийт үнэ (мян. төг)		Хаанаас олгох	Сумдад хүргэх тээврийн зардал /мон. төг/
<b>I. Баян-Өлгий</b>										
1	Алтай	2174	700	1,521.8	25	100.0	2,500	4,021.8		980.0
2	Буянт	2174	700	1,521.8	25	100.0	2,500	4,021.8	Аймгийн төвийн	630.0
3	Толбо	2174	700	1,521.8	25	100.0	2,500	4,021.8	салбараас	665.0
4	Сарсай	2174	700	1,521.8	25	100.0	2,500	4,021.8		236.3
	Дүн	8696	-	6,087.2	100	-	10,000	16,087.2		2511.3
<b>П. Увс</b>										
1	Тэс	-	-	-	30	100.0	3,000	3,000.0		426.6
2	Зүүнговь	-	-	-	25	100.0	2,500	2,500.0	Аймгийн төвийн	301.5
3	Баруунтуруун	-	-	-	25	100.0	2,500	2,500.0	салбараас	423.0
	Дүн	-	-	-	80	100.0	8,000	8,000.0		1151.1
	Нийт дүн	8696	-	6,087.2	180	-	18,000	24,087.2		3662.4





## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2003 оны 4 дүгээр сарын 23-ны өдөр

Дугаар 97

Улаанбаатар хот

Тогтоол хүчингүй болсонд тооцох тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ тооцсугай.

нь:

"Хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх тухай" Засгийн газрын 2000 оны 2 дугаар сарын 9-ний өдрийн 27 дугаар тогтоолыг хүчингүй болсонд

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД

Н.ЭНХБАЯР

БАЙГАЛЬ ОРЧНЫ САЙД

У.БАРСБОЛД

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2003 оны 4 дүгээр сарын 23-ны өдөр

Дугаар 98

Улаанбаатар хот

Тогтоолд нэмэлт оруулах тухай тогтоолын 11 дүгээр хавсралтад дараахь нэмэлтийг оруулсугай.

Улс төр, нийгэм, эдийн засгийн бодлого, чиглэлд хүн ам болон хөгжлийн асуудлыг тусгахад дэмжлэг үзүүлэх, энэ чиглэлээр салбар хоорондын түншлэлийг бэхжүүлэх, үйл ажиллагааг нь уялдуулан зохицуулах, мэдээллээр хангах зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

44	Хүн ам, хөгжлийн асуудлаархи үндэсний хороо	Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд
----	---	--------------------------------------

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД

Н.ЭНХБАЯР

НИЙГМИЙН ХАМГААЛАЛ, ХӨДӨЛМӨРИЙН САЙД

Ш.БАТБАЯР

"Засгийн газрын комисс, Үндэсний зөвлөл, хороо, ажлын хэсгийн тухай" Засгийн газрын 2002 оны 7 дугаар сарын 3-ны өдрийн 138 дугаар

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2003 оны 4 дүгээр сарын 23-ны өдөр

Дугаар 99

Улаанбаатар хот

Дүрэмд нэмэлт оруулах тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

хурдыг" гэсний дараа "улсын чанартай, хатуу хучилттай замд цагт 70 км, бусад" гэж нэмсүгэй.

Засгийн газрын 1996 оны 9 дүгээр сарын 21-ний өдрийн 239 дүгээр тогтоолоор баталсан "Монгол Улсын Замын хөдөлгөөний дүрэм"-ийн 54-т "хүн тээсэн автобус, троллейбус, ачааны автомашины

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД

Н.ЭНХБАЯР

ДЭД БҮТЦИЙН САЙД

Б.ЖИГЖИД

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2003 оны 4 дүгээр сарын 23-ны өдөр

Дугаар 100

Улаанбаатар хот

Нөөцөд эм, биобэлдмэл бэлтгэх тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

Ч.Улаан, Хүнс, хөдөө аж ахуйн сайд Д.Насанжаргал нарт зөвшөөрсүгэй.

Цаг агаарын хүндрэл, бэрхшээлийн улмаас сульдаж доройтсон малыг эмчлэн тэнхрүүлэхэд шаардагдах малын эм, биобэлдмэлийн нөөц бүрдүүлэхэд зориулан өвс, тэжээл бэлтгэхээр жил бүр хуваарилагдаж байгаа хөрөнгийн 10 хувийг зарцуулж байхыг Санхүү, эдийн засгийн сайд

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД

Н.ЭНХБАЯР

САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН САЙД

Ч.УЛААН

ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН САЙД

Д.НАСАНЖАРГАЛ

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав.  
Хаяг: <<Төрийн мэдээлэл>> эмхтгэлийн зөвлөл.

Улсын Их Хурлын Тамгын газрын  
Хэвлэх хэсэгт хэвлэв.

Улаанбаатар-12  
Төрийн ордон

☎ 329612  
Индекс 14003

☎ 329487  
Хэвлэлийн хуудас 1